

ЗАРИМ УЛС ОРНЫ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ СТРАТЕГИ

Г.Болор-Эрдэнэ

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн ахлах багш, доктор (Ph.D), цагдаагийн хошууч

Товчлол: Энэхүү өгүүлэлээр зарим улс орны цагдаагийн байгууллагын олон нийттэй харилцах стратегийн гол үзэл баримтлал, хэрэгжүүлж байгаа стратеги хөтөлбөрийн онцлог цагдаагийн байгууллагаас олон нийттэй харилцах үйл ажиллагааг хэрхэн оновчтой зохион байгуулах талаар үнэлэлт дүгнэлт өгсөн.

Abstract: In this article, It has almost become generally accepted that the concept of modern police must take into account the changes taking place in society. Therefore, the activities of the police cannot be considered separately: it is always necessary to take into account its dependence on society, its assessment by public opinion. The dominant ideology of law enforcement agencies in Western countries in relations with society at present is the so-called concept of "community-oriented" police activity.

Түлхүүр үгс: Олон нийт, стратеги, үйлчилж хамгаална, түрэмгий цагдаа

Key words. the population, social strategy, serve and protect, aggressive patrolling

Оршил. Орчин үеийн цагдаагийн байгууллагын үзэл баримтлал нь нийгэмд болж буй өөрчлөлтийг мэдрэмтгий хүлээн авч өөрчлөгдөх ёстой гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрдөг. Тиймээс Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь нийгмийн өөрчлөлтөөс хараат, олон нийтийн санаа бодлыг харгалзан үзэх шаардлагатай. Хууль сахиулах байгууллагуудын олон нийттэй харилцах харилцаанд зонхилох үзэл баримтлал нь "Олон нийтэд чиглэсэн" цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа гэж нэрлэгддэг үзэл баримтлал юм.

Цагдаагийн байгууллагын мэргэшсэн байдал, олон нийтийн

ажуулгүй байдлын хангах үйл ажиллагааг зарим талаар иргэд олон нийт "түрэмгий цагдаа" үзэл баримтлалаар хүлээн авах, тухайн үзэл баримтлалыг дэмжигчид байнга шүүмжилж байдаг нийгмийн өргөн хүрээний чиг хандлагын нэг хэсэг юм.

Цагдаагийн байгууллага олон нийттэй харилцахад чиглэсэн үйл ажиллагааг нийгэмд нэгэн төрлийн философийн үзэл баримтлал болгон хөгжүүлж, улмаар тэдний ажилд олон нийтийн зүгээс идэвхтэй үнэлгээ өгдөг байхаар зохицуулах нь зөв юм.

Гэр бүл хүүхдийн хүчирхийлэл, мансууруулах бодис, согтууруулах ундааны хэрэглээ, өсвөр насны хүүхдүүдийн жирэмслэлт, гэмт хэрэг гэх мэт үзэгдэл нь зөвхөн нийгмийн амьжиргааны доод доройтсон хэсэгт хязгаарлагдахаа больсон бөгөөд эдгээр асуудлууд нь нийгмийн бүхэл хэсэгт өргөн тархаж нийгэм бүхэлдээ анхаарал хандуулдаг болсон. эдгээр асуудлыг шийдвэрлэх цорын ганц гарц бол нийгмийн бүхий л анги давхарга иргэдийн оролцоо хамтын ажиллагаа гэдгийг нийгэм өөрөө улам бүр ухамсарлаж байна. Энэ нь харилцаа нь зөвхөн итгэлцэл дээр суурилдаг бөгөөд хэт нэг талын хяналт, шударга бус байдал, тухай цаг үед асуудлыг намжаах гэсэн заль мэхийг хүлээн зөвшөөрдөггүй бөгөөд оролцогч талуудыг заавал улс төрч, урлаг соёлын олны танил, хүн байх ёстой гэсэн дүр төрхийг шаарддаггүй онцлогтой харилцаа юм.

Үндсэн хэсэг

АНУ-ын Бригам Янгийн Их Сургуулийн Олон нийттэй харилцах тэнхимийн судлаачдын нэг доктор Л.Д. Вилсон Нийгэмд хүмүүс хамгийн түрүүнд бие биетэйгээ сайн харилцаа холбоо тогтоохыг эрхэмлэдэг. Орчин үед нийгмийн гишүүдийн хамтын ажиллагаа нь оролцогч талуудын ашиг сонирхлыг

илүү түлхүү авч үздэг болж байна гэж дүгнэсэн байна.⁵⁸

Үүнтэй холбогдуулан нийгмийн гишүүдийн хувьд чухал ач холбогдолтой үнэт зүйлсийн хүрээ нь дараах байдлаар тодорхойлж байна. үүнд:

- Олон нийтийн ашиг сонирхолд шударгаар үйлчлэх;
- Иргэн бүр нийгэмд болж байгаа асуудалд анхаарал хандуулдаг байх;
- Хувийн хүний болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах;
- Гэр бүлийн гишүүд, найз нөхөд, хамт олноо харилцан хүндэтгэх;
- Амьдралын чанар, түүний дотор өөрийн өмч хөрөнгийг хамгаалах, сэтгэл зүйн айдас түгшүүргүй байх.

Эдгээр үнэт зүйлсийн тогтолцоо нь олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааны хэрэгцээг тодорхойлж өгч байна. Үүний зэрэгцээ цагдаагийн байгууллагаас олон нийттэй харилцах үйл ажиллагааны талаарх философийн онцлог хандлагыг тодорхойлон өгч байдаг.

Дэлхийн зарим улсын цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийг авч үзэхэд гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд иргэдийг хамтран ажиллахыг уриалсан шинжтэй байгаа больсон

⁵⁸ Police Chief, 1995, №3, p. 25–27, 37–43.

бөгөөд байнга өөрчлөгдөж байдаг нийгмийн өргөн хүрээний эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн нийгмийн өөрчлөлтийг мэдэрч өдөр тутмын идэвхтэй үйл ажиллагаанд тухайн өөрчлөлтөд тохируулан ажиллахад чиглэсэн хандлатай болсон байна.

Өнөөдөр цагдаагийн олон газар хэлтэс хорин жилийн өмнө төсөөлж ч байгаагүй олон төрлийн үйл ажиллагаа явуулж байна. Иргэд цагдааг “Миний цагдаа, найдвартай хамгаалагч, шударга үнэний билэгдэл” гэж ойлгодог бол цагдаа зөв замаар явж байна гэсэн үг юм. Энэ үзүүлэлт нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэхэд ашиглагдаж байгаа нийгмийн үр дүнтэй байдлын гол шалгуур юм.

Цагдаагийн алба хаагчийн имижийг “найз ба туслагч”, мэргэжлийн үйл ажиллагааг нь “нийгмийн төлөөх үйлчилгээ” гэж тодорхойлох нь цагдаа-олон нийтийн хоорондын харилцааг төлөвшүүлэхэд гол тодотгож үзэх баримтлал бөгөөд үүнийг олон нийтийн санал бодлоор үнэлэх гол шалгуур болдог.

Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн байгууллага гэсэн философи баримталснаар цагдаагийн байгууллага иргэдэд ямар төрлийн цагдаагийн үйл

ажиллагаа хамгийн тохиромжтойг тодорхойлохын тулд олон нийтийн дунд нээлттэй санал асуулга ярилцлага өрнүүлэх нь чухал гэж үзэж байна. Орчин үеийн цагдаагийн байгууллагын системийг үндэслэгч Сэр Роберт Пил Английн цагдаагийн байгууллагыг нийгэмд хууль, дэг журмыг сахиулах албан ёсны үйл ажиллагаанаас гадна албан бус үйл ажиллагааг тусгаж өгсөн байна.

Цагдаагийн байгууллагын тухай ном зохиолд Их Британид цагдаагийн байгууллагын гол амжилтын нууц нь олон нийтийн санал бодлыг байнга харгалзан үздэг хамааралтай байдаг үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлэхэд нөлөөтэй байна гэж дүгнэсэн байна⁵⁹.

Үүнийг 1929 онд Пил хотын цагдаагийн газрын анхны эрх зүйн баримт бичигт тусгасан бөгөөд энэ нь өнөөг хүртэл тус улсын цагдаагийн байгууллагын үзэл баримтлалын үндэс болжээ.

Лондоны Цагдаа бол мөн чанараараа бусдаас ялгаатай ч үйлчилж буй ард түмэнтэйгээ дэлхийн өөр аль ч улсад байдаггүй нягт холбоотой байдаг байгууллага юм. Лондонгийн цагдаа бол зүгээр нэг нийтийн хэв журмыг сахиулагч биш, нийгмийн амьдралын салшгүй хэсэг, олон гудамж, ядуусын

⁵⁹ Critchley T.A. A history of police in England and Wales, –London, 1978.

хороололд тэрээр зөвхөн хууль, дэг журмыг сахиулагч биш, тэр бол манай гудамжны жинхэнэ эзэн юм. Өөр зөвлөх, хамгаалагчгүй олон түмний хамгийн сайн найз⁶⁰. гэж Их Британийн цагдаагийн алба олон нийтэд цагдаагийн байгууллагын ажилтны бүтээлч энэрэнгүй дүр төрхийг бий болгохоор шийдэж энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулсан нь үр дүнгээ өгсөн. Энэ нь олон нийттэй харилцах үзэл баримтлалын чухал хүчин зүйл болсон бөгөөд Цагдаа олон нийтийн дэмжлэгийг их хэмжээгээр алдвал энэ онцлог чанараа цаашид хадгалагдах боломжгүй болох талаар алба хаагчдаа ч ойлгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна.

Орчин үеийн Австралийн цагдаагийн иргэд олон нийттэй харилцах харилцаа нь нэгдүгээрт, хүмүүстэй харилцах үндсэн зарчмууд, өөрөөр хэлбэл нийгмийн болон ёс суртахууны хувьд хүмүүсийн зан төлөвтэй холбоотой бүх асуудалд хүмүүсийн ашиг сонирхол нэгдүгээрт тавигдана. Цагдаагийн алба хаагч нь нийгмийн бүх гишүүдийн ашиг сонирхол, гэмт хэрэгтэн хохирогч, энгийн иргэдийн эрх ашигт нийцүүлэн ажиллах ёстой гэсэн үг юм.

Олон нийттэй харилцах орчин үеийн аргын үндэс нь төвийг

сахих арга бөгөөд цагдаагийн алба хаагч нарын сэтгэлгээнд хувьсгал хийхийг шаарддаг. Цагдаагийн ажилтан бүр асуудлыг амжилттай шийдвэрлэхийн тулд хичээл чармайлт гаргах ёстой гэсэн шинэ үзэл баримтлал юм.

Цагдаагийн байгууллага олон нийттэй харилцах үйл ажиллагааг үр дүнтэй явуулахын тулд нийгмийн хариуцлагаа ухамсарлахыг шаарддаг. Цагдаагийн байгууллагын үндсэн зорилго бол олон нийтийн зүгээс хүсэж байгаа нийгмийн хэрэгцээг хангах явдал юм. Олон нийттэй харилцах үр дүнтэй харилцаа гэдэг нь цагдаагийн байгууллага олон нийттэй харилцахдаа олон нийтийн зүгээс хүсэж байгаа асуудлыг эерэг харилцан ашигтай шийдвэрлэх тухай ойлголт.

Цагдаагийн байгууллага нь нийгмийн нэг бүлгийн эрх ашгийг хангахын тулд нөгөө хэсэг бүлгийн эрх ашгийг нь хохироож болохгүй. Олон нийттэй харилцах харилцааны үндсэн зарчмуудын нэг нь харилцаанд оролцогч талууд аль аль нь шударга байх явдал юм. Эдгээр зарчмуудыг хэрэгжүүлэхдээ хувь хүний нэр төрийг хүндэтгэж онцгой ач холбогдол өгсөн тохиолдолд л боломжтой гэж үздэг ба талуудад өөрийгөө илэрхийлэх, шийдвэр гаргалтад оролцох,

⁶⁰ Цит по переводу № cp-54614 Критчли Т.А. История полиции в Англии и Уэльсе, Лондон, Констебль, 1978 стр.46

аюулгүй байдлаа хангах хэрэгцээ шаардлагыг нь нэн түрүүнд анхаарч үзэх нь үр дүнтэй гэж тодорхойлдог.

Энэхүү цагдаагийн байгууллага олон нийттэй харилцах үзэл баримтлалын гол цөм болох хүний эрх, эрх ашгийг нь дээдлэх нь иргэдийг цагдаагийн байгууллагад итгэх итгэл, харилцан ойлголцлыг байнга өдөөж өгч байдаг ач холбогдолтой нь харагдаж байна.

Нийгэм олон нийттэй харилцахдаа цагдаагийн алба хаагч бүр үйлчилж байгаа хүмүүстэйгээ харилцахдаа хүний эрх, эрх ашгийг нь дээдлэх зарчмыг өөрийн үйл ажиллагаандаа хэм хэмжээ болгож хэвшүүлснээр олон нийтийн итгэлийг хүлээхэд ихээхэн нөлөө үзүүлдэг сайн талтай юм.

Нийгэмд таатай сэтгэгдэл төрүүлэхийн тулд аль болох олон нийтийн эрх ашиг сонирхлыг хүндэтгэж үйл ажиллагаагаа явуулах, цагдаад итгэх олон нийтийн хүндэтгэл, итгэлийг алдагдуулдаг олон нийтийг бухимдуулж, үл ойлголцол үүсгэж байдаг ажил ажиллагааг аль болох багасгах нь олон нийттэй харилцах харилцааг амжилттай явуулах үндсэн суурь нь болж өгдөг. Энэ үйл ажиллагаа нь цагдаагийн байгууллагын олон нийттэй харилцах үйл ажиллагааны цагаан толгой бөгөөд үүний үндсэн дээр

цагдаа олон нийтийн хоорондын эерэг харилцаа бүрэлдэж бэхжэнэ гэж үздэг юм. Чөлөөт, ардчилсан нийгэмд гүйцэтгэх засаглалын салшгүй хэсэг болох цагдаагийн байгууллагын үүрэг бол иргэдийн улс төр, эдийн засаг нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох бүсийг бий болгож хамгаалах явдал юм.

ХБНГУ-д олон нийт иргэдийн байр суурийг цагдаагийн байгууллагаас судлан үзэхэд ардчилсан улс оронд аливаа зөрчилдөөнийг хууль эрх зүйн хүрээнд тогтоон барих нь зөв бөгөөд шаардлагүй тохиолдолд зөрчилдөөнийг хууль эрх зүйн хүрээнд таслан зогсоох шаардлагагүй, харин ч эсрэгээрээ хүлээцтэй хандаж тодорхой тогтоож өгсөн хязгаарыг давсан үед шийдэмгий, шаардлагатай арга хэмжээг авах аргыг хослуулсан хэрэглэх нь зүйтэй гэж дүгнэсэн байна. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын цагдаагийн байгууллагын олон нийттэй харилцах үзэл баримтлалд олон нийтийн санаа бодлыг харгалзан үзэж, цагдаагийн байгууллага нь ямар ч нөхцөлд үүргээ гүйцэтгэх чадвартай байхын тулд олон нийтийн цагдаад итгэх итгэлийг бий болгож цаашид хэвээр нь хадгалахыг үргэлж хичээх ёстой гэж дүгнэжээ⁶¹. Цагдаагийн байгууллага

⁶¹ Kube Edwin Public expectations and police role concepts: federal republic of Germany, The Police chief, 1976, may, pp.52–55.

олон нийттэй харилцах харилцааны ямар чухлыг ухамсарлах ёстой. Цагдаагийн байгууллага олон нийтийн зүгээс ирэх хэрэгцээ шаардлага, итгэл найдварт нийцүүлэн ажиллаж, боловсруулсан бодлогын үр дүнг иргэдэд мэдээлж байх шаардлагатай.

Орчин үеийн цагдаа нь иргэдэд төдийгүй нийгэмд ашиг тусаа өгөх алба гэсэн ерөнхий чиг хандлагыг сайжруулах ёстой. Энэ тал дээр нэг талаас цагдаагийн байгууллагын нэр хүнд, тэдний ажилд итгэх итгэл, нөгөө талаас нийгэм цагдаад итгэх хүсэл эрмэлзэл хоёрын харьцааг байнга харгалзаж дүгнэж байх ёстой юм.

Цагдаа иргэдийн хооронд шударга ёсыг тогтоох тал дээр талцсан байнгын сэргөлдөөнд байдал ажиглагдах ба цагдаагийн байгууллага олон нийттэй нэгдэх нь энэ асуудлыг шийдвэрлэхэд олон талаар тусалдаг. 1960-аад оноос Баруун Европын ихэнх орнууд цагдаа, олон нийтийн харилцааг сайжруулахад анхаарч эхэлсэн. Олон нийттэй харилцах үр дүнтэй стратеги нь олон нийтийн тогтвортой оролцоог хангах замаар цагдаагийн үйл ажиллагааг сайжруулах гэж үзсэн байдаг. Үүнтэй холбогдуулан хууль сахиулах үйл ажиллагаанд цагдаа нийгмийн харилцааны илэрхийлэл бөгөөд олон нийтийн санаа бодлыг илэрхийлж байдаг. 1990 оноос хойш Англид олон нийтийн дунд цагдаа

“үйлчилж хамгаална” гэсэн уриа өргөн тархсан байна.

“Хяналт тавихын оронд тусал” гэдэг бол цагдаагийн байгууллагын ажлын шинэ арга биш, үйл ажиллагааны шинэ үзэл баримтлал юм. Олон нийтийн цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа гэдэг нь цагдаагийн байгууллага юуны өмнө иргэдийн хэрэгцээ шаардлагад анхаарлаа хандуулах ёстой гэсэн үг. Аюулгүй байдал бол цагдаа, олон нийтийн хамтын хүчин чармайлт бөгөөд эхний ээлжид иргэдийг баривчлах бус, эхлээд ард иргэддээ үйлчлэх үйл ажиллагаа юм. Хяналт шалгалт гэхээсээ илүү иргэд олон нийтэд тусалж дэмжих тал дээр анхаардаг байна. Цагдаагийн алба хаагчид гагцхүү хэв журам сахиулах үйл ажиллагааны явцад иргэдтэй харилцаж байгаа үед цагдаа олон нийт иргэдийн хоорондын харилцаанд сөрөг хандлага илэрдэг.

АНУ-ын цагдаагийн алба хаагч нарын өдөр тутмын үйл ажиллагааны дүрэмд цагдаа нар нийгмийн ажилтны үүргийг гүйцэтгэх ёсгүй гэж заасан байдаг боловч харин цагдаа нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж байгаа ажиллагаанд идэвхтэй оролцох ёстой гэж заасан байна. Цагдаа нар өөрсдийгөө гэмт хэрэгтэй тэмцэгч бус нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд гол туслагч нь гэж үзэх ёстой. Цагдаагийн алба хаагч нийгмийн үнэт зүйл болох

хамгийн сайн арга бол тэд өөрсдийгөө нийгмийн нэг салашгүй гишүүн болох явдал гэж ойлгох хэрэгтэй⁶². Америкийн цагдаагийн түүхэнд хамгийн эгзэгтэй үеийг 20-р зууны эхний хагаст тохиолдсон гэж судлаачид үздэг. Түүхэн энэ үеийг авлига ашиг сонирхлын зөрчилдөөний улмаас цагдааг нийгмээс тусгаарлах гэж оролдсон оролдлого байсан гэж дүгнэжээ.

Өргөн утгаар нь авч үзвэл цагдаагийн алба хаагч нарыг олон нийтэд тодорхой үйлчилгээ үзүүлэхээр хөлслөн авдаг төрийн албан хаагчид, тэдний ажил бол зөвхөн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавихаас гадна хүмүүсийн хоорондын харилцаанд хөндлөнгөөс оролцох явдал юм гэж тодорхойлсон⁶³. Цагдаагийн алба хаагч нар эцэст нь янз бүрийн асуудлаар тусламж хүссэн хүсэлтийг хүлээн авч, үүнийг цагдаагийн байгууллагын хууль ёсны үйл ажиллагааны чухал хэсэг гэж үздэг хандлага бүрэн тогтдог байна.

1957 онд Олон улсын цагдаагийн байгууллагын дарга нарын бага хурлаас баталсан Хууль сахиулах ёс зүйн дүрэмд "... Би өөрийн байгууллагын тэмдэг, олон нийтийн итгэлийн бэлгэдэл, олон нийтийн итгэл бэлгэдэл гэж ойлгож,

хууль ёсны дагуу ажиллах болно." Зааж өгчээ. Тиймээс цагдаагийн байгууллагын орчин үеийн нийгмийн үзэл баримтлалын үндсэн элемент бол алба хаагчид олон нийтэд үйлчилж, үйлчилж буй олон нийтээсээ тусламж авах явдал гэж тодорхойлсон. Цагдаа байгууллага олон нийтийн харилцаа сайн байх нь нийгмийн ямар ч давхаргын иргэдийн янз бүрийн асуудлаар тусламж хүссэн хүсэлтийг үл тоомсорлохгүй гэсэн итгэлээс ихээхэн шалтгаална.

Дүгнэлт

Гадаадын ном зохиол өгүүлэл нийтлэл, материалыг нэгтгэн дүгнэж үзвэл, тухайн улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой "Иргэд олон нийтэд үйлчлэх" нийгмийн стратегийн нэг элемент болон бусад улс оронд өргөн тархаж байна гэж дүгнэж байна. Энэ нь цагдаа олон нийтийн хамтын ажиллагааны гол үзэл баримтлал болоод зогсохгүй цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдаж байна. Энэ нь хүмүүнлэг үзэл, хувь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах зарчмуудыг ардчилсан эрх зүйт нийгмийн гол шалгуурын нэг юм.

⁶² Wiatrowski M.D. Formal and Informal Social Control: the Police and the Community USA, Departament of Criminal Justice, Florida Atlantic University, 1988, April, pp. 101–109.

⁶³ C.H. Patric. The Police, Crim and Society, USA, 1972, p.37.

Цагдаагийн байгууллага нь иргэд олон нийтийнхээ сэтгэл санааг мэдэхгүйгээр нийгэмтэй нэгдэх боломжгүй Олон нийтийн санаа бодлыг харгалзахгүйгээр тэдний амьдралд тулгарч буй томоохон асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм.

"Иргэд олон нийтэд үйлчлэх" цагдаагийн стратегийн онцлог нь түүхэн тодорхой нөхцөл байдал, янз бүрийн улс орны нийгэм, соёлын хөгжлийн онцлогт тохирсон нийгмийн үйл явцад дасан зохицож, байнга хөгжиж байна. Олон нийттэй харилцах стратегийн хүчин зүйл нь иргэд олон нийтийн амин чухал хэрэгцээ аюулгүй байдал, дэг журам, үнэт зүйлийг хамгаалах явдал юм. Цагдаагийн байгууллага өөрсдийн ашиг сонирхлоос илүү нийгмийн ашиг сонирхлыг түлхүү авч хэрэгжүүлснээр цагдаагийн байгууллагын ажлын үр дүн нийгэм

дэх нэр хүнд, цагдаагийн алба хаагчдыг хүндлэх хүндэтгэл, талархал эрс нэмэгддэг байна.

Ашигласан материал:

1. Police Chief, 1995, №3, p. 25–27, 37–43.
2. Critchley T.A. A history of police in England and Wales, – London, 1978.
3. Цит по переводу № ср–54614 Критчли Т.А. История полиции в Англии и Уэльсе, Лондон, Констебль, 1978 стр.46
4. Kube Edwin Public expectations and police role concepts: federal republic of Germany, The Police chief, 1976, may, pp.52–55.
5. Wiatrowski M.D. Formal and Informal Social Control: the Police and the Community USA, Departament of Criminal Justice, Florida Atlantic University, 1988, April, pp. 101–109.
6. C.H. Patric. The Police, Crim and Society, USA, 1972, p.37.